



ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ- ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Илтгэгч: Ү.ТӨМӨРХУЯГ /"ДЦС-4" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал/



Агуулга

01

Удиртгал

02

“ДЦС-4” ТӨХК-ийн Эрчим хүчний үйлдвэрлэл

03

Зохицуулалтын үр нөлөө

04


Дүгнэлт, санал




ХУРААНГУЙ

Төвийн бүсийн нэгдсэн системийн **63.3%**, Улаанбаатар хотын дулаан хангамжийн **55.3%**-ийг дангаар үйлдвэрлэж буй “ДЦС-4” ТӨХК-ийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, тарифын болон диспетчерийн зохицуулалтын үр нөлөө, цаашид хэрэгжүүлж болох зохицуулалтын талаар товч санал, дүгнэлтийг тавьж байна.

Төвийн бүсийн ЦЭХ-д эзлэх хувь



УБ хотын ДЭХ-д эзлэх хувь



УДИРТГАЛ



САЛБАРЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН ТҮВШИН

Сүүлийн 10 жилд ЦЭХ-ний



тус тус өссөн байна.




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ


2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр:



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ




“ДЦС-4” ТӨХК-ИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ

ЦЭХ-НИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТИЙН ГРАФИК




ТБНС-ийн ЦЭХ-ний хэрэглээ сүүлийн **10** жилд **79,5%**-иар өссөнөөс “ДЦС-4” ТӨХК-ийн цахилгаан эрчим хүчний түгээлт **2,7** тэрбум кВтц-аас **3,9** тэрбум кВтц хүрч, **1,3** тэрбум кВтц буюу **39,2%**-иар нэмэгдсэн байна.



СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ

- 2016 онд Турбоагрегат №7-ийн 123 МВт-ийн шинээр суурилуулах төсөл
- 2019 онд Турбоагрегат №1, 4-ийн шинэчлэлийн төсөл
- 2020 онд Турбоагрегат №2, 3-ын шинэчлэлийн төсөл




СУУРИЛАГДСАН ХҮЧИН
ЧАДАЛ

Цахилгаан эрчим хүч = **789 МВт**
Дулааны эрчим хүч = **1373 Гкал**



ҮНДСЭН ТОНОГЛОЛЫН АЖИЛЛАСАН ЦАГ

Сүүлийн 4 жилд



Ажилласан цаг

45725-52179 цаг

↑ 12,3%

44153-49856 цаг

↑ 11,4%

Засвар хийх хугацаа

15407-12103 цаг

↓ -21,4%

15420-8533 цаг

↓ -44,6%



“ДЦС-4” ТӨХК-ИЙН ЦЭХ-НИЙ ӨСӨЛТ

Үзүүлэлт	нэгж	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Зуух	тоо	7	7	7	7	7	7	7	7	7	8	8
Турбин	тоо	6	6	6	6	6	7	7	7	7	7	7
Цахилгааны дээд ачаалал	МВт	582	568	580	588	600	670	640	640	670	640	753
Зуух ачаалал	тн/ц	393	382	410	414	405	441	440	440	440	400	445
Дулааны ачаалал	Гкал/ц	518	662	593	679	580	573	623	650	694	727	790

Оргил ачаалалын үед цахилгааны дээд ачаалал **753** МВт болж 2011 онтой харьцуулахад **185** МВт болж **32,6%**-аар, дулааны дээд ачаалал **790** Гкал/ц болж **210** Гкалц буюу **36,4%**-аар тус тус өссөн байна.



ҮНДСЭН ТОНОГЛОЛЫН АЖИЛЛАГАА

2019-2020, 2020-2021 оны өвлийн их ачаалалын үед 8 зуух тус бүр **445** т/ц-ийн ачаалалтай уурын нөөцгүйгээр ажилласан. Цаашид дулааны ачаалал нэмэгдэж **790** Гкал/ц-аас **924** Гкал/ц болж нэмэгдэхэд уурын нөөцөнд хязгаарлагдаж, цахилгааны боломжит дээд чадал **753** МВт-аас **600** МВт болж буухаар байна.



ЗУУХ №9-ИЙГ ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ



ТБНС-ний цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй дулааны эрчим хүчний хэрэглээг хангах, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх дээд хүчин чадлыг бууруулахгүй байх, өвлийн оргил ачаалалд бэлтгэх тоноглолын засвар хийх нөхцлийг хангах зэрэг шалтгааны улмаас “ДЦС-4” ТӨХК-д уурын шинэ эх үүсвэр зайлшгүй нэмэх шаардлага гарч байна.

9-р зуух ашиглалтанд орсноор жилд **600,0** сая.кВтц ЦЭХ үйлдвэрлэж, станцын дундач цахилгаан ачаалал **70** МВтц-аар өснө. Харин өвлийн оргил ачааллын үед дулааны ачааллыг **130** Гкал/ц-аар нэмэгдүүлж **235,6** мян.Гкал дулаан түгээх боломж бүрдэнэ.



ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ




ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

2020 оны үнэ тариф тогтоосон байдлаас харахад “ДЦС-4” ТӨХК-ийн дундаж тариф **65.19** төгрөг ба бусад үйлдвэрлэгч ТЗЭ-ийн тариф /импорт орсон/ **107.73-457.77** төгрөг/кВтц байна. Нэгдсэн сүлжээнд хамгийн хямд үнэтэй цахилгаан эрчим хүчийг нийлүүлэн нийт цахилгаан эрчим хүчний **59.4%**-ийг хангасан байхад мөнгөн урсгалын хувь хэмжээ **34.2%** байгаа нь бусад үйлдвэрлэгчдэд **288.4** тэрбум төгрөгийн хөндлөн татаасыг өгч, хэрэглэгчдийг хямд найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах боломжийг бий болгосон.




ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Нийт эх үүсвэрүүдийн эзлэх энергийн хэмжээ



Нийт эх үүсвэрүүдийн орлогын хуваарилалт




ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ




ЭХЗХ-оос үнэ тарифын зохицуулалтыг шаардлагатай үед хийж байснаар бид:

- 2018 онд **1.8** тэрбум төгрөгөөр хүчний трансформатор солих, **3.1** тэрбум төгрөгөөр хурц уурын шугам хоолойн шинэчлэх,
- 2021 онд **2.3** тэрбум төгрөгөөр Зуух№1, Зуух№4-ийн экран хоолой солих ажлуудыг тус тус хийснээр үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа сайжирч, үр өгөөжөө өгч байна.



ТУРБОАГРЕГАТ №1-4-ИЙН ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ҮР ДҮН



Сүүлийн 4 жилд цахилгаан эрчим хүчний түгээлт **613,0** сая кВтц-аар өссөн нь импортын ЦЭХ-ийг бууруулж, Нэг худалдан авагчийн баланс тэнцлийг **122.8** тэрбум төгрөгөөр сайжруулсан байна.



ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эрчим хүчны зохицуулах хорооноос **“Урамшуулалт зохицуулалт”**-ын хүрээнд эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зардал буруулах, эрчим хүч хэмнэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор **“Зорилгоор урамшуулах”**, **“Үр дүнгээр урамшуулах”** гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй **“Урамшуулалт зохицуулалтын гэрээ”** байгуулан гэрээний **“Үр дүнгээр урамшуулах”** зохицуулалтын хүрээнд цахилгаанд жишмэл түлшний хувийн зарцуулалтыг **291.49** гр.кВтц-аас багаар барьж олгосон урамшуулал нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг дээшлүүлэх, зардал хэмнэхэд ажилтнуудын идэвхи санаачлагыг өрнүүлсэн ажил болсон.



ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Диспетчерийн зохицуулалт хийхдээ мөрдөх “Нэгдсэн сүлжээний дүрэм”, “СПОТ зах зээлийн арилжааны дүрэм”, “Импортын цахилгаан эрчим хүчний графикын хазайлтыг тооцох журам”, “Аж ахуйн харилцааны дүрэм”-үүдэд заасан зарим заалтууд хэрэгжихгүй байна.

Тухайлбал,

- Техник технологи, стандартын шаардлагад нийцүүлэх заалтын биелэлт хангалтгүй
- Хамгийн бага өртгийн шалгуурыг үндэслэх заалтыг мөрддөггүй
- Хэрэглээний захиалгаа үнэн зөв бодитой өгөөгүй дамжуулах буюу түгээх ТЗЭ-дэд ноогдуулах хариуцлага хэрэгжихгүй байна



ДҮГНЭЛТ, САНАЛ



ДҮГНЭЛТ, САНАЛ

2001 оноос Эрчим хүчний салбар зохицуулалтайгаар үйл ажиллагаагаа явуулж 20 дахь жилтэйгээ золгоод байна. Бид өмнө нь үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу Диспетчерийн график мөрдөж, төлөвлөгөөт даалгаварыг биелүүлэн ажилладаг байсан. Харин үнэ тарифийн зохицуулалт орж ирснээр дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөөн үүсэж, хүчин чадал ашиглалт үйлдвэрлэгч бүр дээр сайжирч, ДХЦЭХ буурч, эрчим хүчний үйлдвэрлэл өсөж, шинэ эх үүсвэрүүд баригдан суурилагдсан хүчин чадал нэмэгдсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан нь манай салбарын хөгжилд зохих хувь нэмрээ өгөөд байна.



ДҮГНЭЛТ, САНАЛ

Диспетчерийн болон үнэ тарифын зохицуулалтыг уялдуулан өөрчлөлт, шинэчлэлт хийх дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Олон улсын нийтлэг жишгийн дагуу бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан индексжүүлэлт бүхий тарифын тогтолцоонд шилжих бодлогоо тууштай хэрэгжүүлэх
2. Хэрэглээний өсөлтийг бага үнэтэй ЦЭХ-ээр хангах, үйлдвэрлэгч ТЗЭ-ийн өрсөлдөх сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор, энергийн тарифыг тооцох аргачлалд өөрчлөлт оруулж, цахилгаан дулаанд зарцуулсан нийт хувьсах зардлаар тогтоох, эсвэл төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг “тусгай тариф”-аар зохицуулах



ДҮГНЭЛТ, САНАЛ

3. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний арилжаа “Нэг худалдан авагч”-тай загвар нь үр өгөөжөө өгөн хэрэгжиж байгааг илүү сайжруулж, зах зээлийн оновчтой загварыг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна
4. Цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлт хангах, жилдээ **600** сая кВтц цахилгаан эрчим хүч нэмж үйлдвэрлэсэнээр импортын цахилгаан эрчим хүчийг багасгах ач холбогдолтой 9 дүгээр зуухны төслийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
5. Технологийн уурын үнэ нь бодит өртөгтөөс хэт доогуур байгаа, мөн хэрэглэгч өөр зориулалтаар ашиглах нь нийтлэг байгаа тул технологийн уурын үнийг нэмэх шаардлагатай байна. “ДЦС-4” ТӨХК хувьд **30** МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх энергээр технологийн уур боловсруулахад зарцуулж байна.

АНХААРЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

